



**ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 14/11

Баян-Өндөр сум


**Г Монголын Хүүхдийн спортын өвлийн
VIII их наадмын шигшээ тэмцээнд
хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/77 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын Хүүхдийн спортын өвлийн VIII их наадмын шигшээ тэмцээнд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтын дагуу санхүүжилтийн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын хэлтсийн дарга (Э.Лхамсүрэнбаатар), үндэсний болон өвлийн спортын асуудал, сургалт, дасгалжуулалт хариуцсан мэргэжилтэн (О.Заяа) нарт үүрэг болгосугай.

3. Шигшээ тэмцээнд зарцуулагдах 35,900,000 (гучин таван сая есөн зуун мянга) төгрөгийг зохих журмын дагуу нэмэлт санхүүжилтийн зардлаас гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Д.ДЭЛГЭРБАЯР

Биеийн тамир, спортын газрын даргын
2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн
10/11 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛЫН ХҮҮХДИЙН СПОРТЫН ӨВЛИЙН
VIII ИХ НААДМЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

1. Улаанбаатар хотод оролцох спортын төрлийн төсөв:

№	Спортын төрөл	Зардлын нэр	Өдөр	Хүний тоо		1 бүрийн үнэ	Бүгд дүн (төгрөгөөр)
				Тамирчин	Дасгалжуулагч		
1	Гүйлтийн тэшүүр, шорт трек	Байр	5	10	2	25,000	1,500,000
		Хоол	5			30,000	1,800,000
		Зам зардал Эрдэнэт-УБ-Хандгайт-УБ-Эрдэнэт 1400км	5			289л x 2,490	720,000
		Дүн		10	2		4,020,000
2	Шайбтай хоккей	Байр	5	27	2	25,000	3,625,000
		Хоол	5			30,000	4,350,000
		Зам зардал (ирэх, буцах)	2			30,000	1,740,000
		Дүн		27	2		9,715,000
		Нийт дүн		37	4		13,735,000

2. Орхон аймагт оролцох спортын төрлийн төсөв:

Д/д	Спортын төрөл		Тамирчдын тоо	Дасгалжуулагчийн тоо	Хариуцсан албан хаагч	Бүгд
1	Гүйлтийн цана		12	2	1	
2	Уулын цана		12	1		
3	Снүебоард		5	1		
4	Тусгай олимп	Цасны гуталтай гүйлт	2	1	1	
5		цана	2			
	Дүн		33	5	2	40

№	Зардлын нэр	Өдөр	Хэдэн удаа	Хүний тоо	1 бүрийн үнэ	Бүгд дүн (төгрөгөөр)
1	Хоол	5	3	38	13,754	7,840,000
2	Байр	5	-	38	23,605	4,485,000
	Дүн					12,325,000

№	Зардлын нэр	Хүний тоо	1 бүрийн үнэ	Бүгд дүн (төгрөгөөр)
1	Бэлтгэлийн хувцас	82	120,000	9,840,000
	Дүн			9,840,000

Их наадмын төсвийн нийт дүн: 35,900,000 төгрөг

----oOo----

